



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/81

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хужирт сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын холболтын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: - Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Гишүүд: -Б.Мөнхбат -Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө
оруулал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Д.Уранцэцэг –аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүү
хариуцсан ажилтан

А.Оюунчимэг Орон нутгийн сургалт, судалгааны хөгжлийн
агентлаг ТББ-ын удирдах зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100290